

# Утасны төлбөр

Сар бүр Монголын Цахилгаан Холбоо компани хэрэглэгчдээсээ утасны төлбөрийг нь хүлээн авдаг. Танд энэ компаниас хэрэглэгчийн төлбөрийг бодох програм бичих хүсэлт гаргаж байна.

Хэрэглэгчийн яриа 7 секундээс бага хугацаанд үргэлжилсэн бол энэ дуудлага үнэгүй. Харин хэрэглэгч бүхэл бус минутын турш ярьсан бол энэ ярианы уртыг бүхэл минут болгохын тулд дээш нь тоймлоно. Жишээ нь 9 минут 3 секунд үргэлжилсэн яриаг 10 минут гэж тоолно.

Нэг минутын ярианы төлбөр бүх сүлжээнд  $P$  төгрөг бол хэрэглэгчийн сарын төлбөрийг ол.

## Input

Оролтын эхний мөрөнд нэг минутын ярианы төлбөр болох  $P$  бүхэл тоо байна.  $P$  нь 1-ээс 1000 гэсэн завсарт орших бүхэл тоо.

Хоёр дахь мөрөнд хэрэглэгчийн хийсэн ярианы тоо  $K$  байна ( $1 \leq K \leq 1000$ ).

Дараагийн  $K$  мөрөнд ярианы үргэлжилсэн хугацаа  $mm:ss$  хэлбэрээр өгөгдөнө ( $0 \leq mm, ss \leq 59$ ).

## Output

Хэрэглэгчийн нийт төлбөрийн утгыг гаргана.

## Example

**Input:**

1  
4  
00:59  
10:00  
18:01  
00:02

**Output:**

30